



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.13 № 3/415
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Хилийн цэргийн 0288 дугаар анги" ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

"Хилийн цэргийн 0288 дугаар анги" ТӨААТҮГ-ын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

"Хилийн цэргийн 0288 дугаар анги" ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Хилийн цэргийн 0288 дугаар анги" ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлан, түүний тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.


Худалдан авсан цахилгааны 23 орчим хувийг алдаж байна гэж тооцоолсан ба мөнгөөр илэрхийлбэл 72,859.7 мянган төгрөг болж байна. Эндээс цахилгааны түгээлтэнд хяналт тавьж чадахгүй, алдаж байна гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол "Хилийн цэргийн 0288 дугаар анги" ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



**ХИЛИЙН ЦЭРГИЙН 0288 ДУГААР АНГИ
ТӨААТҮГ-ЫН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

САГ-ын дарга Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг:

Naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням

Утас: 260512

Цахим хаяг:

Sambuunyamya@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Батсайхан

Утас: 96658809

Цахим хаяг: batsaikhann@audit.gov.mn

Багийн ахлагч: П.Ариунаа

Утас: 96660444

Туслах ажилтан: Б.Цэцэгсайхан

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй
дүүрэг, Жуулчны гудамж Капитал
центр 10 давхар 1005 тоот

Цахим хаяг:

info@confidenceaudit@mn

Утас: 322431, 70119100

Факс: 70139100

Аудитын тайлан

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Материаллаг байдал
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хилийн цэргийн 0288 дугаар анги ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-2017/1/СТА-ААТҮГ аудитыг “Конфиденсе аудит” ХХК хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хилийн цэргийн 0288 дугаар анги ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн өмчит байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Хилийн цэргийн 0288 дугаар ангийн удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төрийн өмчит байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС -тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хилийн цэргийн 0288 дугаар анги ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн завсар үеийн аудитыг 2016 оны 10 дугаар сарын 24-нөөс 2016 оны 11 дүгээр сарын 04 –ний өдөр хүртэл шалгасан, санхүүгийн тайлангийн 2016 аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 20-ноос 2017 оны 3 дугаар сар 05–ны хооронд хийхээр төлөвлөн аудитын багийн ахлах аудитор П.Ариунаа, туслах ажилтан Б.Цэцэгсайхан нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-8/

Хилийн цэргийн 0288 дугаар анги ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 22-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 20-ноос 2017 оны 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 10-нд Хилийн цэргийн 0288 дугаар анги ТӨААТҮГ-ын захиралд гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Хилийн цэргийн 0288 дугаар анги ТӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал нь Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Компанийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль НББ-ийн хууль болон зарим заавар журам, түүнд нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, дотоод журам, зааварт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Хил Хамгаалах Ерөнхий Газрын дэргэдэх “Хилийн цэргийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ нь Хил Хамгаалах Ерөнхий Газрын харъяа болон Улаанбаатар Төмөр Зам, Тагнуулын Ерөнхий Газар зэрэг ангиудын захиалгаар дүрэмт хувцас оёх, Газар тариалангаар хил дээрх тариалан эрхлэх боломжгүй цэргийн ангийг хүнсний ногоогоор хангах, Хэнтий аймагт Аварга тосон амралтын газар ажиллуулж хилчид болон энгийн иргэдэд үйлчлэх, Орон сууцны ашиглалтын үйлчилгээгээр Баянзүрх дүүргийн 72-р хотхонд байгаа орон сууцны 400 айл өрх, 19 аж ахуйн нэгж байгууллагуудын цахилгаан, засвар, ус, дулаанаар хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хилийн цэргийн 0288 дугаар анги ТӨААТҮГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс гүйцэтгэх захирлын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд балансын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5-3/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 26 горим сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-А-7/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Хилийн цэргийн 0288 дугаар анги ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх тусгайлсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй.

Хилийн цэргийн 0288 дугаар анги ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Хилийн цэргийн 0288 дугаар анги ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн Ритус ХХК-ний НОЁН програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Хилийн цэргийн 0288 дугаар анги ТӨААТҮГ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянаж үзэхэд ус цахилгаан дулааны борлуулалтад дотоод хяналтын шалгалт хийгдэж тайлан бэлтгэгдсэн байна.

Материаллаг байдал:

Тус байгууллага төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар учраас нийт хөрөнгийн 0.2 хувиар төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцож үзэхэд 3,662.0 мянган төгрөг болж байсан ба 2016 оны санхүүгийн тайлангаар дахин тооцож үзэхэд 3,514.7 мянган төгрөг болж байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны хуулийн дагуу 2016 оны 01-12 дугаар сард орлогын 44 гүйлгээний нийт 3,139,756.5 мянган төгрөгөөс 13 буюу нийт 945,337.5 мянган төгрөгийн орлогын гүйлгээг, зардлын 98 гүйлгээний 2,430,402.5 мянган төгрөгөөс 4 буюу 58,357.4 мянган төгрөгийг шилэн дансны мэдээлэлд оруулаагүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 27 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан 26 горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Хилийн цэргийн 0288 дугаар анги ТӨААТҮГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг

бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, орлого, бусад орлого, авлага, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаанууд илрүүлсэн тэдгээрийг залруулсан боловч дараах алдаа зөрчлүүд байна. Үүнд:

1. Худалдан авсан цахилгааны 23 орчим хувь нь тодорхой бус, хяналтгүйгээр алдагдал болсон ба энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Алдагдлыг мөнгөн дүнгээр илэрхийлвэл 72,859.7 мянган төгрөг байна.

Шийдвэрлэсэн нь: Удирдлагын захидлаар цахилгааны алдагдлыг мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж, тоолуурын бичилтийг сарын эцсийн өдрөөр тасалбар болгож байх талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

2. Санхүүгийн тайланд эздийн өмчийн дүн 1,390,491.5 мянган төгрөгөөр тайлагнагдсан ба улсын бүртгэлийн гэрчилгээнд 447,400.0 мянган төгрөг буюу 943,091.5 мянган төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрүү үүссэн шалтгааныг шалгаж алдааг залруулах шаардлагатай ба аль зөв үлдэгдлээр санхүүгийн бүртгэл болон улсын бүртгэлийн гэрчилгээний дүнг зөв болгох талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

3. ХХЕГ-т татан төвлөрүүлэх хөрөнгө гэж ХХЕГ-ын орлогч даргын тушаалаар 2016 онд 33,320.0 мянган төгрөгийг бэлнээр төлж, 62,620.0 төгрөгийг банкаар шилжүүлж, 31,602.3 мянган төгрөгийн төмс хүнсний ногоог зарлагдсан байна. Дээрх гүйлгээнүүд нийт 127,582.3 мянган төгрөг болж байна.

Шийдвэрлэсэн нь: Удирдлагын захидалд цаашид төвлөрүүлж байгаа хөрөнгийг ХХЕГ-ын банкин дахь харилцах данс руу нь шилжүүлж байхыг зөвлөмж хүргүүлэв.

4. Тус байгууллагаас цахилгаан авч орон сууцны барилга барьсан Ай Ди Си Проперти ХХК нь 2016 онд цахилгааны төлбөр хэт их гарч байгаад шалгалт хийлгэх хүсэлт ирүүлснээр тус ангиас шалгалтын баг гарч ажилласан. Шалгалтын ажлын дүгнэлтээр 2015 болон 2016 онд тоолуурын бичилтийг нэг орон ухрааж буруу бичсэнээр Ай Ди Си Проперти ХХК-г 182,181.1 мянган төгрөгөөр хохироосон байна гэж дүгнэсэн ба илүү төлөлтийг буцаан олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Үүнтэй холбоотой залруулгыг нягтлан бодогч буруу хийсэн байсныг буцааж зөв дүнгээр залруулсан.

5. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд 100,706.2 мянган төгрөгийн өртөгтэй хөрөнгийн элэгдэл нь өртгөөсөө 9,217.1 мянган төгрөгөөр илүү буюу хасах үлдэгдэлтэй гарсан байсан.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийж бүртгэлийг үнэн зөв болгосон.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Нэг төрлийн материалыг байнга худалдан авч дүрэмт хувцас оёдог. Худалдан авалт бүрийн дүн өөр байгаагаас хамааран тухайн материалыг өөр өөр кодоор санхүүгийн програмд бүртгэж байна. НББ бодлогодоо ЭАЭЗ аргаар бараа материалыг зарлагадна гэж заасан боловч баримтлаагүй байна.

Шийдвэрлэсэн: Ижил төрлийн материалыг санхүүгийн програмд орлого авахдаа нэг кодоор оруулж байх нь зүйтэй ба НББ-ийн бодлогодоо ЭАЭЗ аргыг баримтлана гэсний дагуу санхүүгийн програмдаа өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Цахилгааны алдагдал 23 орчим хувь буюу 72,859.7 мянган төгрөгийн алдагдал, өмчийн бүртгэлийн зөрүү 943,091.5 мянган төгрөг, ХХЕГ-т татан төвлөрүүлэх хөрөнгө гэж ХХЕГ-ын орлогч даргын тушаалаар дамжуулан шилжүүлсэн 127,582.3 мянган төгрөгийн гүйлгээг эс тооцвол залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

ХХЕГ-ын орлогч даргын тушаалаар ХХЕГ-т татан төвлөрүүлэх хөрөнгө гэж 127,582.3 мянган төгрөгийн хөрөнгө шууд зарлагдаж байгаа нь бүртгэлд тавих хяналтыг сулруулж эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

ХХЕГ-т төвлөрүүлсэн хөрөнгийг банкны харилцах данс руу нь хийсэн эсэхийг шалгах

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл:

Хилийн цэргийн 0288 дугаар анги ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,343,150.0 төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 199,616.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,143,533.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас 3 зөвлөмж өгсөн нь 2016 оны санхүүгийн тайланд хэрэгжүүлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Худалдан авсан цахилгааны 23 орчим хувь нь тодорхой бус, хяналтгүйгээр алдагдал болсон ба энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Алдагдлыг мөнгөн дүнгээр илэрхийлвэл 72,859.7 мянган төгрөг байна.

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол Хилийн цэргийн 0288-р анги ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



ХИЛИЙН ЦЭРГИЙН 0288 ДУГААР АНГИ ТӨААТҮГ 2016 ОНЫ ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1. Орон сууцны цахилгааны алдагдал, тоолуурын бичилтийн тасалбар болголтын талаар

Асуудал 2. Дүрмийн сангийн бүртгэлийн талаар

Асуудал 3. ХХЕГ-ийн нэрийн өмнөөс хийж байгаа төлбөрүүдийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:

Асуудал 4. Бараа материалыг санхүүгийн программд бүртгэж байгаа талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Хилийн цэргийн 0288 дугаар анги ТӨААТҮГ удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хилийн цэргийн 0288 дугаар анги ТӨААТҮГ байгууллагын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1. Орон сууцны цахилгааны алдагдал, тоолуурын бичилтийн тасалбар болголтын талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Борлуулж чадаагүй цахилгааны алдагдал ойролцоо тооцооллоор 23% буюу 72,859.7 мянган төгрөг байна.

Цахилгаан, усны тоолуурыг сар бүрийн 15-20-ны хооронд тасалбар болгож бичилт хийдэг. Ингэж сарын дундуур бичилт хийж байгаа нь санхүүгийн тайлагналын хугацаатай зөрж байна.

.

ҮАГ-ын зөвлөмж

Цахилгааны алдагдал бууруулах ажил зохион байгуулж алдагдал яг хаана байгаа, ямар шалтгаанаар алдаж байгаагаа мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж алдагдлыг бууруулах, тоолуурын бичилтийг сарын эцсийн өдрөөр тасалбар болгож байх. Үүнтэй уялдуулан цахилгаан, дулаан, усны нэгдсэн тоолуурын бичилтийг мөн сарын эцсийн өдрөөр бичиж байхаар холбогдох байгууллагуудтай тохирч ажиллах.

Эрсдэлүүд

Цахилгааны алдагдал нь бодит биш байх

Тоолуурын бичилтийн тасалбар болголт санхүүгийн тайлангийн хугацаатай тохирохгүй байх

Гүйцэтгэх захирлын хариу

Асуудлын бүртгэлд тусгаж байгууллага холбогдох ажилтнуудад танилцуулж хариу авсан

Асуудал 2. Дүрмийн сангийн бүртгэлийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Санхүүгийн тайланд эзний өмчийн дүн 1,390,491.5 мянган төгрөгөөр тайлагнагдсан ба улсын бүртгэлийн гэрчилгээнд 447,400.0 мянган төгрөг буюу 943,091.5 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

Эрсдэлүүд

Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх дүрмийн сан дутуу илэрхийлэгдсэн байх

ҮАГ-ын зөвлөмж

Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх дүрмийн сангийн өөрчлөлтийг өөрчлөлт гарсан тухай бүрт нь өөрчлөлт оруулах, цаашид дүрмийн сан дансанд ТӨХ-ны шийдвэрээр бичилт хийдэг байх

Гүйцэтгэх захирлын хариу

Асуудлын бүртгэлд тусгаж байгууллага холбогдох ажилтнуудад танилцуулж хариу авсан

Асуудал 3. ХХЕГ-ын өмнөөс хийж байгаа төлбөрүүдийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

2016 онд 127,582.3 мянган төгрөгийн төлбөрийг ХХЕГ-ийн өмнөөс бусдад бэлнээр болон, дансаар төлсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Ийм хэмжээний төлбөр төлөх нь зайлшгүй үүрэг даалгавар бол ХХЕГ-ын данс руу нь хийж байх шаардлагатай байна. Гол анхаарах зүйл бол бэлнээр их хэмжээний төлбөр хийхийг хатуу хориглох шаардлагатай байна.

Эрсдэлүүд

Их хэмжээний бэлэн мөнгөөр гүйлгээ хийсэн, бусдын данс руу шилжүүлсэн нь хөрөнгө эрсдэлд орсон байх магадлалыг бий болгож байна.

Гүйцэтгэх захирлын хариу

Асуудлын бүртгэлд тусгаж байгууллага холбогдох ажилтнуудад танилцуулж хариу авсан

Асуудал 4. Бараа материалыг санхүүгийн программд бүртгэж байгаа талаар	Тэргүүлэх ач холбогдол №3
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Нэг төрлийн материалыг байнга худалдан авч дүрэмт хувцас оёдог. Худалдан авалт бүрийн дүн өөр байгаагаас хамааран тухайн материалыг өөр өөр кодоор санхүүгийн програмд бүртгэж байна. Үйлдвэрлэлд материалыг тавьж олгохдоо НББ-ийн бодлогын баримт бичигт заасан ЭАЭЗ өртгийн аргыг хэрэглээгүй байна

Эрсдэлүүд

НББ-ийн бодлогоо баримтлаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Ижил төрлийн материалыг санхүүгийн програмд орлого авахдаа нэг кодоор оруулж НББ-ийн бодлогын баримт бичигт заасан аргаар бүртгэж санхүүгийн програмдаа оруулах нь зүйтэй байна.

Гүйцэтгэх захирлын хариу

Асуудлын бүртгэлд тусгаж байгууллага холбогдох ажилтнуудад танилцуулж хариу авсан

**ХИЛИЙН 0288 ДУГААР АНГИ ТӨААТҮГ-ЫН АУДИТ ХИЙГДСЭН
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/төгрөг/

Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3	56,516,721	39,978,446
Дансны авлага	4	622,205,922	248,666,442
Ндаатгалаас авах авлага	5	1,194	-
ОАТ авлага	5	5,913,805	11,604,049
ХАОАТ авлага	5	1,015,419	984,149
НӨАТ тохируулга	5	8,328,639	-
Бусад авлага		294,354	84,309
Мал амьтан		30,540,000	45,335,000
Бараа материал	6	383,626,197	190,902,468
Бэлэн бүтээгдэхүүн	6	44,801,188	299,182,400
Хангамжийн материал	6	59,981,394	70,992,921
Эргэлтийн хөрөнгийн дүн		1,213,224,834	907,730,184
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	7	896,210,688	862,641,860
Биет бус хөрөнгө	8	329,360	279,360
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		896,540,048	862,921,220
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		2,109,764,881	1,770,651,403
ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧ			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	9	349,400,211	173,130,318
НӨАТ-н өглөг	9	2,102,239	1,015,716
Зээлийн өглөг	9	3,000,000	2,000,000
Урьдчилж орсон орлого		-	2,722,838
Богино хугацаат өр төлбөрийн дүн		354,502,450	178,868,871
Эзний өмч			
Хувьцаат капитал		1,390,491,528	1,390,491,528
Өмнөх үеийн үр дүн		162,465,186	281,752,168
Тайлант үеийн үр дүн		202,305,717	(80,461,164)
Эзний өмчийн дүн		1,755,262,431	1,591,782,532
ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН		2,109,764,881	1,770,651,403

**ХИЛИЙН 0288 ДУГААР АНГИ ТӨААТҮГ-ЫН АУДИТ ХИЙГДСЭН
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

/төгрөг/

Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
Борлуулалтын орлого	10	3,460,855,933	2,846,887,709
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	10	2,705,309,013	2,274,211,729
Нийт ашиг	10	755,546,920	572,675,981
Үйл ажиллагааны бус бусад орлого		36,623,871	35,032,343
Хүүний орлого		3,772,313	5,818,879
Алданги торгуулийн орлого		6,859,577	11,500,002
Хандив тусламжийн орлого		-	1,210,000
Ерөнхий удирдлагын зардал	11	487,382,684	533,576,696
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз		2,101,607	6,015,410
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз		18,626,005	2,800,003
Бусад зардал		62,960,850	144,516,715
Татвар төлөхийн өмнөх ашиг		231,731,535	(60,671,620)
Орлогын албан зардал		29,425,818	19,789,544
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ		202,305,717	(80,461,164)

**ХИЛИЙН ЦЭРГИЙН 0288 ДУГААР АНГИ ТӨААТҮГ-ЫН АУДИТ ХИЙГДСЭН
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/төгрөг/

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2014 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	1,390,491,528	364,078,196	1,754,569,724
Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт, залруулга		(201,613,010)	(201,613,010)
Тайлант үеийн үр дүн		202,305,717	202,305,717
2015 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	1,390,491,528	364,770,903	1,755,262,431
Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт, залруулга	-	(83,018,735)	(83,018,735)
Тайлант үеийн үр дүн	-	(80,461,164)	(80,461,164)
2016 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	1,390,491,528	201,291,004	1,591,782,532

**ХИЛИЙН 0288 ДУГААР АНГИ ТӨААТҮГ-ЫН АУДИТ ХИЙГДСЭН
2016 ОНЫ ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого		
Борлуулалт болон худалдан авагчдаас орсон мөнгө	4,023,776,268	3,639,003,342
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	6,757,239	5,035,324
Татаас санхүүжилтаас орсон мөнгө	-	-
Бусад орлого	15,872,580	19,175,141
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,046,406,086	3,663,213,807
Ажиллагчидтай холбогдсон зардал		
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		
Цалин	569,632,045	685,575,746
Нийгмийн хамгааллын шимтгэл		
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	105,967,000	123,968,579
Бараа, үйлчилгээний урсгал зардал		
Бусад бараа үйлчилгээний зардал		
Түүхий, эд материал худалдан авахад төлсөн мөнгө	2,367,496,927	1,883,895,697
Түлш шатахуунд төлсөн мөнгө	7,350,000	400,000
Ашиглалтанд төлсөн мөнгө	591,292,935	691,278,129
Төлсөн татвар	323,519,035	76,105,840
Бусад	30,335,780	222,231,154
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,995,593,722	3,683,455,145
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	50,812,364	(20,241,338)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Худалдаж авсан хөрөнгө	2,000,000	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	2,000,000	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Зээл авсан мөнгө		279,000,000
Төрөл бүрийн хандив		4,700,002
Бусад орлого	24,600	3,061
Хүүгийн орлого	3,274,355	-
Зээлийн төлбөрт төлсөн мөнгө		280,000,000
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	3,298,955	3,703,063
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	52,111,319	(16,538,275)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,405,402	56,516,721
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	56,516,721	39,978,446